

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

Улаанбаатар хот
2026 он

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй “Хууль тогтоомжийн тухай хууль” болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар боловсрууллаа.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр иргэнд зардал үүсгэх шууд зохицуулалт шинээр нэмэгдээгүй. Харин төрийн болон төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болон ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болон цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч /Улаанбаатар хотын Дулааны цахилгаан III, IV-р станцууд/-н хувьд зардал үүсэхээр байна. Иймд хуулийн төслийн зардлын тооцоог төрийн байгууллага болон хуулийн этгээдийн хувьд тооцож гаргана.

Ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх дараах төрийн болон орон нутгийн байгууллагууд байна. Үүнд:

- Засгийн газар;
- Ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл;
- Улаанбаатар хотын дулааны цахилгаан III, IV-р станц.

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

1.1.Ус хангамж, ариутгах татуургын асуудал хариуцсан төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;

А. Гүйцэтгэх засаглал

4 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх		
1.	4.1.4.дахин ашиглах цэвэрлэсэн усны хэрэглээг тогтвортой нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай дэмжлэг үзүүлэх.	Засгийн газар хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Хуулийн төслийн 4.1.4 дэх заалтад дахин ашиглах цэвэрлэсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын дэмжлэг үзүүлэхээр тусгасан.

Энэхүү зохицуулалт нь бодлогын шинжтэй бөгөөд зардал үүсгэх шууд үйл ажиллагааг тодорхой тусгаагүй тул зардлыг таамаглаж тодорхойлох боломжгүй байна.

Б. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хорооны бүрэн эрх

5 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх		
2.	10.4. Дахин ашиглах цэвэрлэсэн усны чанар, найрлага, хэрэглээний зориулалтад тавих шаардлагын хэрэгжилтэд тогтмол хяналт, мониторинг хийх, стандартын шаардлага хангаагүй усыг хүлээн авах, түгээхээс татгалзах.	Тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хорооны бүрэн эрх
3.	10.5. Ус дахин ашиглах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам болон дахин ашиглах цэвэрлэсэн усны чанар, аюулгүй байдалд тавих стандарт, техникийн зохицуулалтыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран батлах.	Тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хорооны бүрэн эрх

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэгт дахин ашиглах цэвэрлэсэн усны чанар, хэрэглээнд хяналт, мониторинг хийх, ус дахин ашиглах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагааны журам, стандарт, техникийн зохицуулалтыг батлах үүргийг тус тус хүлээлгэсэн.

Эдгээр үүрэг нь төрийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах бөгөөд шинээр бүтэц, орон тоо бий болгохгүйгээр хэрэгжих боломжтой.

В. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй холбоотой зохицуулалт

19¹ дүгээр зүйл.Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр		
4.	19 ¹ .1.Хот, суурины төвлөрсөн цэвэрлэх байгууламж болон бусад эх үүсвэрээс гарч буй хаягдал усыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, ахуйн бус зориулалтаар дахин ашиглах цэвэрлэсэн ус үйлдвэрлэнэ.	Гадаад харилцааны яамаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар, Мянганы Сорилтын Корпорацаар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс хооронд байгуулсан "Мянганы сорилтын компакт гэрээний хүрээнд хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа буюу шинэ Төв цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усыг дахин боловсруулж, гурав болон дөрөвдүгээр ДЦС-д нийлүүлэх үйлдвэрийг холбогдох дэд бүтцийн хамт байгуулах төслийг бүрэн хэрэгжүүлж, хүлээлгэн өгсөн бөгөөд хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтыг шинээр хуульд оруулж байна.
5.	19 ¹ .2.Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг байгуулах, ашиглалтад оруулах, үйл ажиллагаа явуулахад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэж, холбогдох төрийн захиргааны байгууллагын баталсан журам, стандарт, техникийн шаардлагыг мөрдөнө.	Улаанбаатар хотын хоногийн усны хэрэглээ 150–170 мян. м ³ байгаа бөгөөд хотын усан хангамжийн 98% нь гүний уснаас шууд хамраалтай бөгөөд Улаанбаатар хотын усан хангамжийн тогтолцоо нь хүн амын хурдацтай өсөлт, хотжилт, аж үйлдвэрийн өргөжилт, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан ноцтой дарамтад орж, өсөн нэмэгдэж буй эрэлтэд нийцүүлэн найдвартай, тогтвортой эх үүсвэр бий болгох, байгаа нөөцөө хамгаалах, дахин ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол 2030 оноос эрэлт нийлүүлэлтээс давж, хот ундны усны хомстолтой тулгарах бодит эрсдэл нүүрлэж байна. Иймд хаягдал усыг дахин ашиглах зайлшгүй шаардлага тусгарч байгаа бөгөөд хаягдал ус цэвэрлэх үйлдвэр байгуулах, үйл ажиллагаа явуулахад холбогдох дүрэм, журам, стандартыг дагаж биелүүлнэ.
	19 ¹ .3.Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн	Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулж

6.	үйлдвэрлэсэн дахин ашиглах цэвэрлэсэн усны чанар, аюулгүй байдал, хэрэглээний зориулалтыг холбогдох стандартын дагуу тогтмол хянаж, хяналтын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлнэ.	буй үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, ангилах ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэсэн байх шаардлагын биелэлтийг хангах зорилгоор усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.
7.	19 ¹ .4.Дахин ашиглах цэвэрлэсэн усыг унд, ахуйн зориулалтаар нийлүүлэх, хэрэглэх, ашиглахыг хориглоно.	Хаягдал усыг дахин ашиглах зориулалтын тогтоосон бөгөөд өөр зориулалтаар хэрэглэх, ашиглахыг хуулиар хориглоно.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй холбоотой зохицуулалт тусгагдсан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд уг үйлдвэрийг УСУГ-ын харьяанд 38 орчим ажилтан, албан хаагч ажиллах, материаллаг зардал, бусад зардлын тооцоо дараагийн хэсэгт оруулсан болно.

1.2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн зохицуулалтуудаар хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах Засгийн газар, Зохицуулах хороо, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн хүлээлгэсэн үүрэг буюу төсөл, хөтөлбөр, санал, аргачлал, журам, дүрэм, стандарт баталж мөрдүүлэх, үйлдвэрийг хэвийн ажиллуулах, ил тод мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах давтамж тогтмол биш эсхүл жилдээ 1 удаа гүйцэтгэх тул аргачлалын дагуу давтамжийг 1 гэж тооцлоо.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төслийн Засгийн газарт хамаарах 4.1.4 дэх заалт, Зохицуулах хороонд хамаарах 10.4, 10.5 хэсэг, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрт хамаарах	Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй холбоотой зохицуулалт	мэдээлэл цуглуулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Цуглуулсан мэдээллийг нэгтгэн судалж, үнэлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төсөл болон танилцуулга боловсруулах	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төслийг холбогдох газар нэгжүүдэд хүргүүлж, санал авах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн төслийг эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480

19 ¹ .1-19 ¹ .4 дахь хэсэг амаарна	Баримт бичгийн төсөлтэй танилцаж, шаардлагатай мэдээлэл цуглуулах, бусад холбогдох байгууллагаас санал авч нэгтгэх	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
	Баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан батлах	1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
Нийт		5760		

Дээрх хүснэгтэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй холбоотой зохицуулалтад хамаарах журам, аргачлал, тариф боловсруулах, батлахтай холбоотой 1 үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тооцов.

Энэхүү тооцооллыг хуулийн төслийн Засгийн газарт хамаарах 4.1.4, Зохицуулах хороонд хамаарах 10.4, 10.5, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрт хамаарах 19¹.1-19¹.4 дахь хэсэг, заалтуудад заасан үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Нэг жилд шаардагдах ажлын цаг/минут	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Засгийн газар	5760=5760 минут/ 96 цаг	96000	0,06
Зохицуулах хороо	5760*15=86400 минут/1440 цаг	96000	0,9
Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр	5760*630=3628800 минут/ 60480 цаг	96000	37.8

Дээрх тооцооллоос харахад хаягдал ус дахин боловсруулах үйлдвэртэй хамаарах дэмжлэг үзүүлэх, журам, аргачлал, тариф боловсруулах, батлах, хяналт тавих, үйлдвэрийг хэвийн ажиллуулахтай холбоотой үүргийг хэрэгжүүлэхэд:

1. Засгийн газарт 5760 минут буюу 96 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,06 хүн шаардлагатайг харуулж байна. Иймд хуулийн төсөлд шинээр тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн ачаалал шинээр үүсэхээргүй байна.
2. Зохицуулах хороонд 57600 минут буюу 1440 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,9 хүн шаардлагатайг харуулж байна. Иймд хуулийн төсөлд шинээр тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд Зохицуулах хороо дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн ачаалал шинээр үүсгэхгүй байх боломжтой байна.
3. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр 3628800 минут буюу 60480 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 37.8 хүн шаардлагатайг харуулж байна. Иймд хуулийн төсөлд шинээр тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд УСУГ-т 38 хүний нөөцийн ачаалал шинээр үүсэхээр байна.

Хүний нөөцийн нийт хэрэгцээг тодорхойлох нь

Аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ 1 бүхлээс доош байгаа тохиолдолд тухайн үүргийг дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн ачаалал шинээр үүсгэхгүйгээр зохицуулах боломжтой гэж үздэг.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ
Засгийн газар	0,06
Зохицуулах хороонд	0,9
Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр	37.8

1.3.Гарах зардлыг урьдчилан тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

Шинээр орон тоо нэмэгдэж, ажлын байртай холбоотой зардал Засгийн газар, Зохицуулах хороонд гарахгүй тул хүний нөөцийн болон материаллаг зардал гарахгүй. Харин Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг хэвийн ажиллуулахад УСҮГ-г хүний нөөц, материаллаг болон бусад зардал гарна.

1.4.Зардлыг нэгтгэн тооцож гаргах

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	2.5-3,5 сая ₮	38	$38 \times 2.5 \text{ сая} \times 12 = 1.14 \text{ тэрбум } ₮$ Цалингий хэлзэлийг тооцвол дээд хувилбар: 1.59 тэрбум ₮
Материаллаг зардал	<input type="checkbox"/> цахилгаан <input type="checkbox"/> химийн бодис <input type="checkbox"/> засвар үйлчилгээ <input type="checkbox"/> тоног төхөөрөмж	38	5.1-8.5 тэрбум ₮ / жил
Бусад зардал	1 – 2 тэрбум ₮ / жил	38	1 – 2 тэрбум ₮ / жил
Нийт зардал			7.24-12.09 тэрбум ₮

Дээрх хүснэгтээс харахад Ус хангамж, ариутгах татуургын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу УСУГ-т 7-12 тэрбум төгрөгийн зардал үүсэхээр байна.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ

2.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай. Ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн төсөлд шинээр орсон зохицуулалтууд дахин ашиглах цэвэрлэсэн ус ашиглах тохилдолд үйлчилгээний төлбөрийг талууд гэрээгээр зохицуулах боломжийг нээж, харин уг гэрээг зохицуулах хороонд бүтгүүлэх үүрэг шинээр нэмж байгаа.

Хүлээсэн үүрэг	Агуулга	Стандарт ажиллагаа	үйл	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөц
Хуулийн төслийн 10.1.15-д иргэн, аж ахуйн нэгж дахин ашиглах цэвэрлэсэн усыг авч ашиглах тохиолдолд үйлчилгээний төлбөрийг талууд гэрээгээр тогтоож, тухайн гэрээг Зохицуулах хороонд бүртгүүлнэ;	Талууд дахин ашиглах усыг үйлдвэрлэх, өөрийн хөрөнгөөр барьсан шугам сүлжээ ашиглан дүгээсэн бол хатуу тогтоосон тариф мөрдөхгүй, зах зээлийн зарчмаар гэрээний үндсэн дээр төлбөр төлнө. Харин гэрээний нэг эх хувийг зохицуулах хороонд бүртгүүлнэ.	мэдээлэл цуглуулах		3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Цуглуулсан мэдээллийг нэгтгэн судалж, үнэлэх		1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төсөл болон танилцуулга боловсруулах		1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төслийг холбогдох газар нэгжүүдэд хүргүүлж, санал авах		2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн төслийг эцэслэн боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх		1 өдөр /8цаг/ 480 мин	1	480
		Баримт бичгийн төсөлтэй танилцаж, шаардлагатай мэдээлэл цуглуулах, бусад холбогдох байгууллагаас санал авч нэгтгэх		3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		Баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан батлах		5 өдөр /8цаг/ 2400 мин	1	2400
Нийт				7680		

2.2.Зардал тооцох

Хуулийн төслийн 10.1.15-д иргэн, аж ахуйн нэгж дахин ашиглах цэвэрлэсэн усыг авч ашиглах тохиолдолд үйлчилгээний төлбөрийг талууд гэрээгээр тогтоож, тухайн гэрээг Зохицуулах хороонд бүртгүүлэхэд хуулийн этгээдэд захиргааны зардал гарахгүй. Харин Хуулийн төслийн 15.1.13-д эрчим хүч болон бусад үйлдвэрлэлийн зориулалттай хэрэглээнд газрын доорх цэнгэг усны

хэрэглээг хязгаарлаж, дахин ашиглах цэвэрлэсэн усыг эн тэргүүнд ашиглах талаар тусгасан бөгөөд дахин ашиглах цэвэрлэсэн ус ашиглах хэмжээ, дамжуулах, түгээх зайнаас хамаарч тухайн үед ТЭЗҮ-р зардлын хэмжээ, зарцуулах цаг тодорхой болно.

ГУРАВ. ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛОХ

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөд иргэнд тайлан гаргах, бүртгүүлэх, зөвшөөрөл авах зэрэг үүрэг оногдож байгаа бөгөөд аргачлалын дагуу иргэнд шууд үүсэх захиргааны зардал байхгүй гэж үзэв.